



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№234 /443/ 2022.12.27

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

## ОХУ-ЫН ЭЛЧИН САЙД НОЁН И.К.АЗИЗОВЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Искандер Кубарович Азизовын үүрэгт ажил дуусгавар болон нутаг буцаж байгаатай холбогдуулан хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ноён И.К.Азизовыг 2013 оноос хойш Элчин сайдаар ажиллах хугацаандаа хоёр

улсын харилцаа, тэр дундаа батлан хамгаалахын салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, шинэ шатанд гаргахад дэмжлэг үзүүлж ирсэн явдалд талархал илэрхийллээ. Мөн "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ"-г 2019 онд байгуулахад түүний оролцоо чухал байсан хэмээн цохон тэмдэглэв.

Ноён И.К.Азизов нь Монгол-Оросын харилцаанд батлан хамгаалах салбарын харилцаа,

хамтын ажиллагааг гол цөм бөгөөд хоёр улсын цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгаа хэмээн онцолсон юм.

Уулзалтын төгсгөлд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хоёр улс хоорондын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж "Цэргийн хамтын ажиллагааны төлөө" хүндэт тэмдгээр шагнаж түүний цаашдын ажилд амжилтын дээдийг хүсэн ерөөлөө.

## "СОЁМБОТ" ЦЭВЭР УСНЫ ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙЛЭЭ



Төрийн өмчит үйлдвэрийн газрууд тухайн салбарынхаа хөгжилд хувь нэмрээ оруулдаг, өөрийн гэсэн орон зайтай байх ёстой. Тиймээс Засгийн газраас төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг дэмжих чиглэлд, үр ашигтай байлгах талаар анхаарч ажилладаг.

Тэгвэл "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын "Соёмбот" цэвэр усны үйлдвэр нь 2022 онд ажлын үзүүлэлт, гүйцэтгэл, үр дүнгээрээ төлөвлөгөөт ажлуудаа бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн хэмээн дүгнэгджээ. Тус үйлдвэр нь стандартад нийцсэн тоног төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнээс гадна бусад аж ахуйн нэгж зэрэг 95 байгууллагатай хамтран ажилладаг. Мөн өнгөрсөн онд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэнээр хэрэглэгчдээ эрхэмлэсэн

чанартай бүтээгдэхүүнийг өдөр тутам хэрэглэх боломжийг бүрдүүлсэн юм. Энэ удаад мөн тус үйлдвэрт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгджээ.

Үйлдвэрийн дарга Б.Рагчаасүрэнгийн хэлснээр "Батлан хамгаалах яамны удирдлага техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлд ихээхэн анхаарсан. "Соёмбот" цэвэр усны үйлдвэр нь энэ онд жижиг савлагаат цэвэр усны шинэ төхөөрөмжийг суурилуулан, эхний үйлдвэрлэлээ гаргахад бэлэн болоод байна. Мөн цэвэр усны сав, шошго, бөглөөний дизайныг орчин үеийн шаардлагад нийцүүлж шинэчилсэн. Усны үйлдвэрийн гол давуу тал нь гүний худалтай. Технологийн энэхүү шинэчлэл хийгдсэнээрээ өмнөхөөсөө 2 дахин илүү хүчин чадалтай ажиллах бөгөөд өдөрт 12000-16000 ширхэг савлагаатай цэвэр ус үйлдвэрлэх боломж бүрдэж байгаа" гэв.

## ТЭРГҮҮНИЙ ОРОН ТООНЫ БУС ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ НАРАА ШАГНАЖ УРАМШУУЛАВ

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас нэгтгэл, ангиудынхаа тэргүүний орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарыг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар 2020 онд Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудад орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч томилгогдсон бөгөөд энэ нь ажил, чиг үүргийн ойролцоо байдлаас хамааран тус нэгтгэл, ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга, зааварлагч нар үндсэн ажлынхаа зэрэгцээ хавсарган гүйцэтгэж байгаа юм. Тэд анги, байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилсан илт мэдээ мэдээллийг Хуурай замын цэргийн командлалын хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах офицер болон "Соёмбо" редакцияд



тодорхой хугацааны давтамжтай хүргэж, бие бүрэлдэхүүнээ сурталчлах, орон нутгийнхаа хэвлэл мэдээллийн байгууллагатай хамран ажиллах үүрэгтэй юм. Хуурай замын цэргийн командлалд нэгтгэл, ангиудаас 2022 онд 600 гаруй мэдээлэл ирүүлснээс 400 гаруй нь хянагдан сурталчлагдаж, олон нийтэд хүрчээ. Мэдээллийн дийлэнх хувь нь хугацаат цэргийн алба хаагчдын тухай сурталчилгаа болон ангийн үйл ажиллагааны илт

мэдээлэл эзэлж байна. Тэгвэл нэгтгэл, анги байгууллага сурталчлахад идэвх санаачилгатай ажилласан зарим орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарыг Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар шагнаж урамшуулсан бөгөөд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга, хошууч Д.Ганбаатар, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга, хошууч О.Отгонцэцэг, Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Соёл

хүмүүжлийн албаны дарга, хошууч Л.Амарбаясгалан нар шалгарсан юм. Хуурай замын цэргийн командлалаас өнгөрсөн 8 дугаар сард нэгтгэл, ангиудынхаа орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарт сургалт зохион байгуулж, байнгын бүрэлдэхүүний сургалт бэлтгэлтэй холбоотой мэдээллээс татгалзах, цэргийн дүрэмт хувцасны зөрчилгүй гэрэл зураг ирүүлж байх, үг үсгийн алдаа, утга найруулгад анхаарах зэргийг онцлохын сацуу нэгтгэл, ангийн дотооддоо эрхлэн гаргадаг сонинуудын чанар, хүртээмжийг дээшлүүлж, алба хаагчдадаа ЗХЖШ-ын пэйж хуудас болон веб сайтаас тогтмол мэдээлэл авах ажлыг зохион байгуулахыг уриалсан юм.

Ахмад Д.БОЛОР

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-18	-30

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	21

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.462	3.468
EUR	3.670	3.695
CNY	490	492.50
RUB	48.60	50
JPY	26	26.20
KRW	2.68	2.71

### ЗУРХАЙ



2022.12.27 / ДАВАА ГАРАГ /  
БИЛГИЙН ТООЛЛЫН 30

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР**  
**ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР**

ҮС ЗАСУУЛБАЛ:

Эд мал арвижна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.41-17.05

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 662,150,064

Эдгэрсэн

Нийт: 634,873,448

Нас барсан

Нийт: 6,687,211

Цахим шууданд

# “ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ”-ИЙНХӨН НЭГТГЭЛД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчдын ёс суртахуун, харилцаа хандлага, төлөвшилд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-өөс цуврал сургалтыг зохион байгуулж байна.

Тэгвэл тус “Иргэний зөвлөл”-ийнхөн эгнээнээсээ 10 баатар төрүүлсэн, 2023 онд 100 жилийнхээ ойтой золгох Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд ажиллаж, бие бүрэлдэхүүнтэй сонирхолтой сургамжит яриа, хэлэлцүүлгийг өрнүүллээ. Сургалтын эхэнд Монгол Улсын гавьяат багш, доктор,

профессор, “Отгонтэнгэр” их сургуулийн багш, чөлөөнд байгаа хурандаа Б.Галиндэв “Эх оронч үзэл, бахархал”, Монгол Улсын Төрийн соёрхолт, хүний гавьяат эмч, анагаах ухааны доктор профессор, Цэргийн төв эмнэлгийн зөвлөх эмч, чөлөөнд байгаа хурандаа Л.Жамбалжав “Цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн боловсрол” тэр дундаа нийгмийн халдварт өвчин болох сүрьеэ, БЗХӨ, элэгний вирусийн халдвар зэрэг сэдвээр лекц уншиж, алба хаагчдын сонирхсон асуултад хариулт өгөв.

Мөн Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны мэргэжилтэн, “Иргэний зөвлөл”-ийн нарийн бичгийн дарга, хошууч А.Октябрь Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, зөвлөлийнхний өмнөө тавьсан зорилго, зорилтыг танилцууллаа.

Үргэлжлүүлэн ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн профессор багш С.Мандалмаа “Хувь хүний хөгжил”, “Цагийн менежмент” сэдвийн хүрээнд өөрийгөө хэрхэн хөгжүүлэх, харилцаа хандлагаараа



хэрхэн манлайлах, зөв иргэн байх, албандаа хариуцлагатай, амьдралдаа нөмөртэй хань ижил байхад юу анхаарах гэхчлэн олон сэдвээр мэдээлэл хүргэлээ.

Энэхүү сургалтаар тус нэгтгэлийн бүрэлдэхүүнд цэргийн алба хаагчийн үүрэг, тэдний төлөвшил, ёс суртахуун ямар байх

тухай өгүүлэхээс гадна гэр бүлийн хамтын үүрэг, залуу хосуудын итгэлцэл, хайр халамжийн талаар ярьсан нь үр дүнтэй арга хэмжээ болж чадсаныг холбогдох албаны хүмүүс онцолж байсан юм

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

## МАНЛАЙЛАГЧ ХАМТ ОЛОН



БНМАУ-ын баатар, 4 удаагийн маршал нэрэмжит хүчний 327 анги энэ сарын 26-ны өдөр 2022 оны үйл ажиллагаагаа тайлагнаж, амжилтаа дүгнэлээ. Арга хэмжээнд

Дорнод аймгийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах газрын дарга М.Бадамсүрэн, Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын

дарга дэд хурандаа О.Ганзориг нар оролцлоо.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ Дорнодчууд бидний бусад аймаг, орон нутгаас ялгарах нэг онцлог нь цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил, төлөвшилтэй зон олон болохыг онцлоод орон нутгаас Зэвсэгт хүчний анги, байгууллагынхаа үйл ажиллагааг үргэлж дэмжиж ажиллахаа илэрхийлсэн юм.


Арга хэмжээний төгсгөлд 2022 онд ажил үйлсээрээ хамт олноо тэргүүлсэн бүрэлдэхүүнийг шагнасан бөгөөд “Тэргүүний хамт олон”-оор Орон сууцны алба, “Тэргүүний офицер”-оор ахмад Э.Мөнхбаясах, “Тэргүүн ахлагч”-аар сургагч ахлагч М.Төмөрбарс, “Тэргүүний ажилтан албан хаагч”-

аар орон сууцны цахилгаанчин Ц.Цогтбаатар, “Шилдэг хамт олон”-оор Цэргийн далдуур удирдлага, “Шилдэг офицер”-оор ахлах дэслэгч Б.Сугарням, “Шилдэг ахлагч”-аар ахлах ахлагч А.Мөнх-Эрдэнэ, “Шилдэг ажилтан албан хаагч”-аар нягтлан бодогч Б.Нэргүй нар тус тус шалгарлаа.

“Манлайлагч офицер”-оор ахмад Э.Энхбаяр, “Манлайлагч ахлагч”-аар ахлах ахлагч С.Батцэнгэл, “Манлайлагч ажилтан”-аар номын санч Ц.Алтантуяа, “Шилдэг тамирчин”-аар ахлагч Г.Наранхүү нар шалгарч, шагналыг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, ангийн захирал, хурандаа Н.Цэцэнхүү, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа О.Ганзориг нар гардуулан өгсөн юм. Хошууч Д.ГАНБААТАР



## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧЫН “СЭТГЭЛ ЗҮЙ” АППЛИКЕЙШ ЯАГААД ТАНД ХЭРЭГТЭЙ ВЭ?



Зэвсэгт хүчнээс цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих зорилгоор “Сэтгэл зүйн аппликейшн” бүтээж олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэхээр бэлтгэж байна.

### Аппликейшн яагаад хэрэгтэй вэ?

Цэргийн алба хаагчид өөрт тулгамдсан сэтгэл зүйн төрөл бүрийн асуудлын хариу, зөвлөгөө мэдээллийг

дийлэнхдээ сошиал медиа орчноос авдаг. Гэвч хуурамч ташаа мэдээлэл, мэргэжлийн бус хүний зөвлөгөө нь тухайн хүний сэтгэл зүйн байдлыг улам дордуулах сөрөг нөлөөтэй.

Амьдралын буруу хэв маяг болон сэтгэл зүйн асуудлууд нь хоорондоо нягт холбоотой юм.

Жишээлбэл, Чанартай нойр авахгүй байх нь түгшүүр, сэтгэл гутралд

өртөх эрсдэл нэмэгдэх шалтгаан болдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Тиймээс сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаарах хамгийн энгийн бөгөөд үр дүнтэй арга бол эерэг дадлыг өдөр тутамдаа хэвшүүлэх юм.

Тэгвэл тус аппликейшнээр дамжуулан та хаана ч, хэзээ ч өөрийн сэтгэл зүй, амьдралын хэв маягаа хянах, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх боломжтой.

Цэргийн алба хаагч бүр өөрийн сэтгэл хөдлөлөө анзаардаг, юу мэдэрч байгаадаа анхаарал хандуулдаг байх нь сэтгэл зүйн тогтвортой байдлаа хадгалахад чухал үүрэгтэй төдийгүй сэтгэл санаа тогтворгүйтэх, стрессдэх, ганцаардах, сэтгэл гутралд орох, сөрөг бодлууд бүрэлдэх нь сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй юм.

Тиймээс та бүхэн уг аппликейшнээр дамжуулан сэтгэл санааны байдал, стресс, түгшүүрийн түвшин зэрэг, сэтгэл зүйгээ тандах, хянахын зэрэгцээ сэтгэцийн эрүүл мэнддээ хэрхэн сайжруулах талаар зөвлөмж мэдээлэл авах боломжтой.

Ахмад Б.ЖАВХЛАНТӨГС

## Сургалт

### МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №45

ТА УСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ  
ТА бол дэвсгэр бус үсэг. Тиймээс ямагт ардаа эгшигтэй ордог. Эхэнд ордог хэлбэр нь өнөө цагт хоёр янз буй. Нэг нь тариан түрүүний хэлбэртэй, нөгөө нь буруу харсан гэдэс хэлбэртэй. Тариан түрүүний ТА хэлбэрийг үсэн бийрийн хичээнгүй бичлэгт их төлөв бичдэг бол нөгөө гэдэстэй ТА-г төмөр үзгийн гар бичмэлд, нуруунаас урагш үл гаргаж бичдэг уламжлалтай байжээ. Дунд орсон хэлбэрийг нь уурган ДА, ТА гэж нэрлэдэг.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ТА, ТЭ, ТИ, ТО, ТУ, ТӨ, ТҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой.

Бичмэл тигээр:

